**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 08 сарын 14 өдөр Дугаар А/541 Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Засгийн газрын 2017 оны 69 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд “Тэмүүлэх гал” ХХК-ны хийж гүйцэтгэсэн “Ойжуулалт хийх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх”, “Ховд хотын ногоон байгууламжийн услалтын систем хийх/ А зэрэглэлийн бүс/” зэрэг ажлуудыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганданповрон -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Х.Баасанхүү -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

: Х.Баярлах –Ховд хотын захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

Л.Доржцэрэм –Хот тохижуулах газрын дарга

Б.Бурмаа – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Бөхболд - Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн



02 02682

2. Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд "Тэмүүлэх гал" ХХК-ний хийж гүйцэтгэсэн "Ойжуулалт хийх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх", "Ховд хотын ногоон байгууламжийн усалтын систем хийх/ А зэрэглэлийн бүс/" зэрэг ажлуудыг ажлын даалгавар, тоо хэмжээний дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг  ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Т.ЖАРГАЛСАЙХАН